

2019 ОНЫ 4 САР

АРГА ЗҮЙ

Нээлттэй Нийгэм Форум нь Монголын хуульчдын холбоотой хамтран “Үзэл бодол” цуврал хэлэлцүүлэг эхлүүлээд байгаа бөгөөд эхнийхийг “Гүтгэлэг гэмт хэрэг мөн үү?” сэдвийн хүрээнд зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэг үндсэн хоёр хэсэгтэй бөгөөд эхний хэсэгт зарчмын зөрүүтэй байр суурьтай хоёр зочин өөрсдийн байр сууриа илэрхийлсний дараа зохион байгуулагчдын зүгээс бэлтгэсэн өдөөх баримтуудыг танилцуулах юм. Дараагийн хэсэгт бусад оролцогчийн зүгээс байр сууриа илэрхийлж, хоёр зочинд хандан асуулт тавих боломжтой. Төгсгөлд нь зохион байгуулагчдын зүгээс хэлэлцүүлгийн туршид гарсан гол асуудлуудыг товч дүгнэнэ. “Үзэл бодол” цуврал хэлэлцүүлгийн зорилго нь зарчмын өөр байр суурьтай хүмүүсийг оролцуулж, нэг талаас өөрсдийн баримталж буй үндэслэлээр мэтгэлцэх, нөгөө талаас ялгаатай байр сууриудыг сонсох, харилцан мэдээлэл солилцох, олон улсын туршлага, хүний эрхийн хэм хэмжээний талаарх мэдлэгээ тэлэх боломжийг оролцогчдод олгох билээ. Үүгээр дамжуулан иргэд олон нийтэд нэг талыг барьсан биш, илүү тэнцвэртэй мэдээлэл түгээхийг мөн зорьсон болно.

ГҮТГЭЛЭГ ГЭМТ ХЭРЭГ МӨН ҮҮ?

ЕРӨНХИЙ ТОЙМ

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд өрнөж буй маргаан бүхий асуудлын нэг бол яах аргагүй гүтгэлгийг гэмт хэрэгт тооцох эсэх тухай асуудал билээ.

Гүтгэлгийн асуудлыг хэлэлцэх үед ихэвчлэн “гүтгүүлсэн хохирогчийн байр сууринаас” хандаж, гэмт хэрэгт тооцохыг яаравчилдаг. Хэдийгээр хувь хүний нэр төр, эрхэм зэргийг онцгойлон хамгаалах үүрэг төрд байдаг хэдий ч жингийн тавгийн нөгөө талд байгаа нийтийн ашиг сонирхол, олон нийтийн мэдэх эрхийг хөсөрдүүлэх аргагүй. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг “Иргэний, улс төрийн эрхийн тухай олон улсын пакт” (ИУТЭОУП гэх)¹-д дараах дөрвөн асуудлын хүрээнд авч үздэг. Үүнд:

1. Өөрийн үзэл бодолтой байх;
2. Хүн бүрийн санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх. Мэдээлэл, үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар, эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх;
3. Доорх үндэслэлээр хязгаарлаж болох ч хязгаарлалт нь хуулиар тогтоогдсон байх, хязгаарлах нь зайлшгүй байх;
 - а. Бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;
 - б. Үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах;
4. Дайныг аливаа хэлбэрээр сурталчлах, алагчлан дайсагналцах болон хүчирхийллийг өдөөн турхирдаг үндсэрхэх үзлээр, арьс үндсээр болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа ухуулга сурталчилгааг хуулиар хориглох.

¹ НҮБ-ын Ерөнхий Ассамблей, 2200 А (XXI), Иргэний улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1966 он, Монгол Улс 1974 онд соёрхон баталсан. Зүйл 19, 20

1999-2015 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, гүтгэлэг доромжлолтой холбоотой шүүхээр иргэний 605 хэрэг /үүний 363 нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой/ шийдвэрлэжээ.

“Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2015” 21.

Гүтгэлэгтэй холбоотой энэхүү сэдэв нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хязгаарлалтын хүрээнд өрнөсөн тул ИУТЭОУП-ын 19.3 заалтыг тойрч хэлэлцсэн болно. Юуны түрүүнд Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем буюу www.legalinfo.mn цахим хуудсанд байршуулсан ИУТЭОУП-ын орчуулгатай холбоотой шүүмж гарсныг дурдах хэрэгтэй. Судлаачид Пактыг орчуулахдаа “хязгаарлалт зайлшгүй байх” хэмээх бие даасан ойлголтыг орхигдуулсан гэж үздэг.² Энэ нь НҮБ-ын Хүний эрхийн хорооноос ИУТЭОУП-ын 19-р зүйлд өгсөн 34-р Ерөнхий зөвлөмжид тодорхой дурдагдсан. Тус Хорооноос үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хязгаарлалт “зайлшгүй байх” ёстой гээд энэ нь “үндэслэл бүхий зорилгод” нийцсэн байх ёстойг зөвлөсөн байдаг.³ Мөн хэрэв үзэл бодлоо илэрхийлсний төлөө эрүүгийн хуулиар шийтгэх бол тухайн хэрэг онц ноцтой шинжтэй байх ёстойн зэрэгцээ, “хорих ял” бол ямар ч тохиолдолд тохирох ял шийтгэл биш гэж дүгнэсэн байдаг.⁴

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь туйлын эрх биш бөгөөд тодорхой үндэслэлээр хязгаарлах боломжтой ч энэ нь “зайлшгүй байх”, “тодорхой, бүгдээр хүлээн зөвшөөрсөн үндэслэлүүд буюу бусдын эрх, нэр төр, эрхэм зэрэг, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг

журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах” зорилгод нийцсэн байх, гагцхүү хуулиар хязгаарлах, хязгаарлалтын хэм хэмжээ нь ард түмний мэдэх эрх, нийтийн ашиг сонирхлын асуудлаар үгээ хэлэх эрхийг нухчин дарахааргүй байх ёстой. Сүүлийн жилүүдэд нийгмийн сүлжээ хөгжихийн хэрээр улс орнуудын эрх зүйн тогтолцоонд шинэ зохицуулалтууд орж ирэх болсноор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд шинэ төрлийн хязгаарлалтууд бий болж байна. Тиймээс хамгийн оновчтой шийдлийг олохын тулд асуудлыг олон талаас нь дүгнэн хэлэлцэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Глоб интернэшнл төв ТББ-ын бүртгэлээр 2003-2012 онд буюу 8 жилийн хугацаанд гүтгэх гэмт хэрэгт 27 эрүүгийн хэрэг үүсгэсэн бол 2013-2014 онд буюу 2 жилийн хугацаанд 13 эрүүгийн хэрэг үүсгэжээ. Эдгээр 13 гэмт хэргийн гомдол гаргагч нь эрх мэдэлтэн, төрийн өндөр албан тушаалтан, төрийн байгууллага байв.

“Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2015” 21.

2005-2014 онд буюу 10 жилийн хугацаанд эрүүгийн хэрэг үүсгэсэн “гүтгэх” гэмт хэргийн статистикаас харахад сүүлийн 2 жилд 2 дахин өсөж, тэр тусмаа хохирогч нь төрийн өндөр албан тушаалтан, төрийн байгууллага байгаа нь анхаарал татаж байна. Монгол Улсын Засгийн Газрын ИУТЭОУП-ын хэрэгжилтийн талаарх илтгэлд Хүний эрхийн хорооноос өгсөн дүгнэлт зөвлөмжид⁵ “Хэдийгээр Эрүүгийн хуулиас гүтгэх гэмт хэргийг хассан ч зарим заалт хэвээр байгаа, мөн иргэний хуулиар гүтгэх заалтын хэрэглээ нэмэгдэж байгаа нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд айдас түгшүүр төрүүлж байгаад санаа зовниж байна.”

2 О.Мөнхсайхан, Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь, Эрх зүй сэтгүүл, 2017 он, Цуврал 38, 13-р тал

3 UN Human Rights Committee, General Comment No34 (Article 19), CCPR/C/GC/34, para. 22, 33

4 UN Human Rights Committee, General Comment No34 (Article 19), CCPR/C/GC/34, para.47

5 UN Human Rights Committee, Concluding Observations on the sixth periodic report of Mongolia, 2017, CCPR/C/MNG/CO/6, para. 37, 38

гэж дурдсан байна. Тус Хороо зөвлөхдөө аливаа хязгаарлалт нь Пактын 19.3-т нийцсэн байх ёстой, эрүүгийн, иргэний хууль тогтоомж нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг нухчин дарах хэрэгсэл болох учиргүй хэмээн зөвлөжээ.

Тиймээс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хязгаарлалт, тэр дундаа эрүүгийн

гэмт хэрэгт тооцох нь оновчтой эсэх талаар хэлэлцлээ. Анхны хэлэлцүүлэгт 2012 – 2014 онд Хууль зүйн сайдаар ажиллаж байсан хуульч Х.Тэмүүжин, 2016 – 2018 онд Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдаар ажиллаж байсан хуульч Б.Энхбаяр нар оролцож бодлогын зөрүүтэй шийдлийн талаар үзэл бодлоо илэрхийлсэн юм.

ДҮГНЭЛТ

Хэлэлцүүлгийн туршид үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хязгаарлалт оновчтой биш бол иргэдийн мэдэх эрх, нийтийн ашиг сонирхол зөрчигдөхөд хүрнэ гэдэгт оролцогчид санал нэгдлээ. Мөн эрүүгийн эрх зүйн уламжлалт хандлагаар “гүтгэх” гэмт хэрэгт маш олон төрлийн үйлдлийг хамруулан авч үзэх нь тухайн гэмт үйлдлүүдийн гэм хор, хор уршгийг ялгавартай авч үзэх боломжийг үгүйсгэж, ял шийтгэл оновчтой байх, үйлдсэн гэмт хэрэгт тохирох ял шийтгэл оногдуулах зарчмыг алдагдуулж, улмаар зарим гэмт этгээд ял завших, харин үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах, улмаар нухчин дарах арга хэрэгсэл болох эрсдэлтэй хэмээн ярилцлаа. Тиймээс тухайн гэмт хэрэгт хамааруулан авч үзэж байгаа асуудлыг задлан шинжлэх замаар гэмт хэргийн томьёоллыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байна гэж дүгнэв.

Нөгөө талаар, гүтгэгдсэн хүмүүсийн хохирлыг барагдуулах тухайд өнөөгийн эрх зүйн зохицуулалт хариулт өгч чадахгүй байна гэж үзлээ. Мөн түүнчлэн, эрүүгийн хуульд “гүтгэх” гэмт хэргийг шинээр оруулах бол НҮБ-ын Хүний эрхийн хорооны дүгнэлт зөвлөмжийг гарцаагүй анхаарч үзэх шаардлагатай болохыг мөн онцоллоо.

Цаашид ч бид нийгэмд тулгамдсан, шийдэл эрэлхийлж байгаа асуудлыг сонгож хэлэлцүүлгээ үргэлжлүүлэх болно.

ТАЛАРХАЛ

Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэчлэлийн хүрээнд нарийн төвөгтэй олон асуудал тулгарч байна. Тиймээс бид эдгээр асуудлаар зарчмын зөрүүтэй байр суурийг сонсож, өөрсдийн үндэслэлийг хамгаалан мэтгэлцэх боломжийг талуудад олгох замаар оновчтой зөв шийдэл эрэлхийлэх, нөгөө талаас тухайн асуудлын талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг гүнзгийрүүлэх зорилгоор “Үзэл бодол” цуврал хэлэлцүүлгийг Монголын хуульчдын холбоотой хамтран хийж байна.

“Гүтгэлэг гэмт хэрэг мөн үү?” сэдвийн хүрээнд хийсэн эхний хэлэлцүүлэгт оролцож үзэл бодлоо хуваалцсан хуульч Х.Тэмүүжин, хуульч Б.Энхбаяр нарт талархал илэрхийлье. Мөн санал бодлоо илэрхийлж хэлэлцүүлгийг илүү баялаг агуулгатай болгож, олон талын мэдлэг, туршлагаа хуваалцсан бусад оролцогчдод талархаж байна.

МЭТГЭЛЦЭГЧ ТАЛУУДЫН БАЙР СУУРЬ



Б.ЭНХБАЯР

Хууль зүй, дотоод хэргийн
дэд сайд, 2016-2018 он

Б.Энхбаяр: Гүтгэлэг бол эрүүгийн гэмт хэрэг мөн.

Хүн бүр нэр төр, эрхэмсэг оршихуйтай бөгөөд энэ нь хамгаалагдах ёстой. Энэ үнэт зүйлийг гагцхүү Иргэний хуулиар хамгаалах уу, эсхүл төрийн оролцоотой хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх үү гэдэгт анхаарах ёстой. Ер нь иргэн хоорондын маргаан гээд орхих биш, энэ нь бүх хуулиар хамгаалагдах ёстой. Тиймээс Эрүүгийн хуулиар ч мөн хамгаалагдах ёстой. Эрүүгийн хууль хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, ёс суртахууны хэм хэмжээг хамгаалдаг. Нэр төрд халдаж байгаа үйлдэл нь бодит байдлаас зөрүүтэй буюу түүнд нийцэхгүй мэдээллийг зориуд санаатай тарааж байгаа үйлдэл юм. Тиймээс "гүтгэх" нь бүх шинжээрээ гэмт хэрэг. Санаа зорилготой буюу бодит байдалд нийцэж байгаа эсэхийг нотлоогүй байж санаатай түгээж байгаа үйлдэл юм. Мөнгөөр илэрхийлэгдэх эсэхээс үл хамааран гүтгэлэг нь бодит хор хохирол учруулдаг. Түүгээр ч зогсохгүй нийгмийн үнэт зүйл, ёс суртахуун буюу мөнгөн дүнгээр үнэлэгдэхгүй үнэт зүйлд харшилдаг. Тухайлбал, хүний нэр төрд халдаж болох юм байна гэсэн сэдлийг энэ гэмт үйлдэл төрүүлдэг. Үүнийг өөгшүүлж болохгүй.

Нөгөө талаас авч үзвэл, 2015 он хүртэл цахим орчны хэрэглээ бага байсан. Зонхилох мэдээллийн эх сурвалж телевиз, сонин, цахим хуудас байсан. Эдгээр хэрэгслээр иргэд мэдээлэл авдаг, мөн түгээдэг. Гэтэл хамгийн сүүлд 2019 оны 1-р сард хийсэн судалгаагаар Монгол Улсын иргэдийн 70 орчим хувь нь анхдагч мэдээллээ цахим орчноос авч байна гэсэн дүн гарсан. Өөрөөр хэлбэл, мэдээлэл авдаг анхдагч эх үүсвэр өөрчлөгдсөн. Гэтэл уламжлалт мэдээллийн хэрэгслээр худал мэдээлэл түгээх нь харьцангуй бага. Яагаад гэхээр төрөөс лиценз, бүртгэлтэй, хэрвээ зориуд худал мэдээлэл түгээвэл лиценз хураагдах, үйл ажиллагаа нь зогсох үр дагавартай. Тиймээс ч өөрийн зохицуулалтаар хянагдаж явдаг.

Харин цахим орчинд мэдээлэл нягтлах нь учир дутагдалтай. Тэр ч байтугай нэр, нүүрээ нууцалсан, худал хаягаар зориуд бусдын нэр хүндэд халдах үйлдэл түгээмэл болсон. Бид онолоос гадна практик ярих ёстой. Тухайлбал, төрд дипломат алба хашиж байгаа хүн 100 гаруй сая төгрөгөөр цахим томоохон хаягуудыг худалдаж аваад түүгээрээ төрийн маш олон байгууллага, улс төрчдийг авлаж, зориуд санаатай худал мэдээлэл түгээх ажлыг эрхэлсэн баримт байна. Гүтгүүлсэн хүмүүс хаана хандахаа мэддэггүй.

Х.Тэмүүжин: Гүтгэлэг иргэний хуулиар зохицуулагдах нь зохистой.

Миний бие энэ чиглэлээр мэргэшсэн, дагнан судалдаг хүн биш. Хууль тогтоомж боловсронгуй болгох чиглэлээр олон асуудал хөндөгдсөн. Энэ хүрээнд “гүтгэх” гэдэгт хамаарч байсан олон асуудал салж, ухаалгаар зохицуулагдаж чадсан уу, үгүй юу гэдэг маргаан өрнөж байна гэж ойлгож байна. Хуучин Эрүүгийн хуульд байсан “гүтгэх” гэмт хэрэгт 4, 5 үйлдэл багтдаг. Тухайлбал, хүнийг хүнд гэмт хэрэгт холбогдуулан гүтгэх, иргэд төрийн албан тушаалтныг хардаж, энэ талаар хэлэлцүүлэг өрнөсөн зэрэг асуудлыг нэг зүйлд багтаагаад эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр явж ирсэн. Энэ гэмт хэрэгтэй төрийн албадлага хэрэглэн тэмцэхээр хуульчлагдсан. Тиймээс бид бусад улс орон энэ хэргийг хэрхэн шийдвэрлэж байгаа болон төрийн бус байгууллагууд ямар байр суурьтай байдгийг судалж үзсэн. Энэ хүрээнд 3 зарчмын санал гарсан.

1-рт, хүнийг гэмт хэрэгт холбогдуулан гүтгэх, улмаар нийгмийн зүгээс ялгаварлал, таагүй байдалд хүргэх бол нэлээд хор хөнөөлтэй үйлдэл гэж үзээд үүнийг эрүүгийн хуулиар шийтгэх ёстой, гэхдээ “гүтгэх” гэдэг нэрэн доор биш харин “шүүхэд худал мэдүүлэх”, эсхүл “гэрч худал мэдүүлэг гаргах” гэдгээр зүйлчлэх ёстой гэж үзсэн. Үүнийг “худал мэдүүлэг өгөх” гэж гэмт хэргийг нь томъёолсон. Процессын хуульд нь “Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг” хэмээх шинэ процессыг тусгаж, гэм бурууг хэлэлцэхээс өмнө цугларсан нотлох баримт нь шаардлага хангаж байна уу гэдгээр талууд маргах боломжтой болж, энэ хүрээнд гүтгэсэн эсэхийг тогтоох боломжийг хуульчилсан. Энэ үе шатанд хэн нэгнийг гүтгэсэн, худал мэдүүлэг өгсөн гэдэг нь тогтоогдох юм бол тэр нь тусдаа гэмт хэрэгт тооцогдохоор байгаа. Нэгэнт гүтгэсэн гэдэг нь тогтоогдох юм бол иргэний журмаар хохирлоо барагдуулах боломжтой байхаар зохицуулсан.

2-рт, улс орнууд бүрэн шийдээгүй боловч олон нийтийг төөрөгдүүлэх зорилгоор худал мэдээлэл тараах, нийгмийг хий бухимдалд автуулах замаар өөр чиглэлд нийгмийг хөтөлдөг үзэгдэл популизм газар авсантай холбоотойгоор дэлхий нийтэд тулгамдаж байна. Өнөөдөр үүнийг хэрхэн шийдэх вэ гэдэг дээр бүрэн дүүрэн хариулт олоогүй. Зарим улс “бусдыг үймээн самуунд уруу татах” гэдгээр гэмт хэрэгт тооцож байна. Манай улс яг энэ байдлаар бичиж чадаагүй боловч томъёолохыг оролдсон.



Х.ТЭМҮҮЖИН

Хууль зүйн сайд,
2012-2014 он

Б.Энхбаяр: Гүтгэлэг бол эрүүгийн гэмт хэрэг мөн. (үргэлжлэл)

Дүн шинжилгээ хийгээд үзэхээр тэр хүний нийт дайралтын тал хувь нь Монгол Улсын төрийн тэргүүн, тэгээд улс төрчид голдуу. Улс төрчид нь бараг бүгдээрээ хүүхэд хүчиндсэн гэж байгаа. Энэ бол маш онц хүнд гэмт хэрэгт гүтгэсэн хэрэг. Шүүхэд хандах гэхээр хариуцагч нь тодорхой байх ёстой. Тухайн хүн хэн өөрийг нь гүтгээд байгааг мэдэх боломжгүй. Иргэний журмаар хэргээ шийдүүлэх гэхээр хариуцагчийн хаягийг тодруулахаас эхлээд л боломжгүй болдог. Энэ тохиолдолд төрийн кибер гэмт хэрэгтэй тэмцэх алба л ажиллаж байж тэр хүний хохирсон нэр хүндийг сэргээх боломж гарч ирж байна.

Х.Тэмүүжин: Гүтгэлэг иргэний хуулиар зохицуулагдах нь зохистой. (үргэлжлэл)

З-рт, төрийн албан тушаалтан, иргэд, эсхүл иргэд хооронд байгаа асуудлыг эрүүгийн хуульд байлгах боломжгүй гээд эрүүгийн хуулиас хассан. Гэтэл тухайн үед УИХ-ын гишүүдийн санал хуваагдсан тул завсрын зохицуулалт болгоод Зөрчлийн хуульд оруулсан.

Энэ нь Зөрчлийн хуулийн үндсэн үзэл баримтлал болох "төр, иргэний хоорондын маргааныг зохицуулдаг" харилцаа байтал үүнтэй зөрчилдүүлж "хоёр иргэний хоорондын маргааныг" оруулж ирсэн. Шилжилтийн үеийн зохицуулалт болгоод ядаж хүн гүтгэсэн гээд ял шийтгэл авахгүй, цагдан хоригдохгүй, гүйцэтгэх ажил хийгдэхгүй л гэж үзсэн.

*"Гүтгэх" нь бүх шинжээрээ гэмт хэрэг тул
Эрүүгийн хуулиар зохицуулагдах ёстой.
Б.Энхбаяр*

*Гүтгэлэг иргэний хуулиар
зохицуулагдах нь зохистой.
Х.Тэмүүжин*

VS

САНАЛ СОЛИЛЦСОН АСУУДАЛ

ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХЭД ТАВЬЖ ИРСЭН ХЯЗГААРЛАЛТ ХЭР ОНОВЧТОЙ БАЙСАН БЭ?

2017 оны 7-р сарын 1 хүртэл үйлчилсэн эрүүгийн хуульд байсан⁶ "гүтгэх", "доромжлох" гэмт хэргийг шийдвэрлэж ирсэн практик учир дутагдалтай байв. Тухайлбал, хэн нэгнийг хахууль авсан талаар бичихэд авлигын үйлдэл байсан эсэхийг шалгах биш, харин сэтгүүлчийн бичлэгийг хэл шинжлэлийн мэргэжилтнээр шинжлүүлж, шинжээч тухайн нийтлэлийг гүтгэлгийн шинжтэй, доромжлолын өнгө аястай гэж үзвэл шийтгэл ногдуулж ирсэн. Өмнө нь хийгдсэн харьцуулсан судалгаанаас

үзэхэд хүний эрхийг тууштай хамгаалдаг орнуудад гэмт хэрэгт холбогдуулан гүтгэсэн тохиолдолд түүнийг баталж чадахгүй бол иргэний шүүхээр шийддэг байна. 2017 оны 7-р сарын 1-ээс "гүтгэх", "доромжлох" үйлдлийг гэмт хэрэгт тооцохоо больж, харин "гүтгэх" үйлдлийг зөрчилд тооцож, Зөрчлийн хуулиар хүнийг 2 сая, байгууллагыг 20 сая төгрөгөөр торгохоор зохицуулсан⁷.

Гэвч одоогоор 20 сая төгрөгөөр торгуулсан хэвлэл мэдээллийн хэрэгсэл байхгүй, ихэвчлэн

⁶ Улсын Их Хурал, Эрүүгийн хууль, 2002 он, www.legalinfo.mn, Зүйл 110, 111

⁷ Улсын Их Хурал, Зөрчлийн хууль, 2015 он, www.legalinfo.mn, Зүйл 6.21

энэ үйлдэлд сэтгүүлчийг 2 сая төгрөгөөр торгох практик тогтжээ. Гэтэл энэ нь хэвлэлийн эрх чөлөөний хуулийг зөрчиж байгаа хэрэг бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслээр гүтгэсэн бол редакц хариуцлага хүлээх ёстой. Нөгөө талаас, агуулгад хязгаарлалт тавих хандлага гарч байгаа бөгөөд зохицуулалт тодорхой биш байгаагаас үзэл бодлыг хязгаарлах хэрэгсэл болоод байна. Манайд энэ төрлийн зохицуулалт улс төрийн цензур ч болж болзошгүй юм.

Зөрчлийн хуульд “гүтгэх” зөрчлийг тусгаснаар сэтгүүлчдийн холбогдсон гүтгэлгийн хэргийн тоо өмнөхөөс даруй 7-8 дахин нэмэгдсэн байна. Тус заалтыг төрийн эрх мэдэлтнүүд ихээр ашиглах болсон. Нөгөө талаас, хүнийг

гүтгэж 2 сая төгрөгөөр торгуулчаад, гүтгэлгээ үргэлжлүүлэх нь ч бий.

Өөр нэгэн тулгамдаж буй асуудал бол зөрчлийг шалгах процесстэй холбоотой үүсэж буй хүндрэл болно. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар “гүтгэх” зөрчлийг хорооны цагдаад хариуцуулсан бөгөөд тэрээр энэ төрлийн зөрчлийг шалгахдаа “буруугүй гэдгээ нотлох” үүргийг тухайн зөрчил гаргагчид хүлээлгэж байна. Гэтэл Зөрчлийн хуулиар шийтгэх гэж байгаа бол буруутай гэдгийг төр нотлох үүрэгтэй. Энэ мэтээр зарим зөрчлийг шалгахад иргэний процесс үйлчилж байгаа нь учир дутагдалтай. Тиймээс энэ гажуудлыг засах ёстой.



“ҮЗЭЛ БОДОЛ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ЗОРИУЛАН БЭЛТГЭСЭН ВИДЕО БИЧЛЭГЭЭС...



**Д.ЦЭНД-АЮУШ
ӨМГӨӨЛӨГЧ:**

Гүтгэлэг нь маш аюултай, миний үйлчлүүлэгч амь насаа алдаж, үр хүүхдүүд нь өнчрөн үлдсэн. Тиймээс Эрүүгийн хуульд байх нь зүйтэй...



**Ж.АМГАЛАН
ЦАГДААГИЙН ХУРАНДАА:**

Зөрчилд байснаар гүтгэх зөрчил буурч байна, тиймээс торгуулийн хэмжээг их болгоод энэ хуульд байлгах нь зөв...



**Ц.БУЛГАНЗАЯА
СЭТГҮҮЛЧ:**

Хорооны цагдаа энэ зөрчлийг шалгаж чадахгүй байна. Энэ асуудал иргэний хуулиар зохицуулагдах ёстой...



**Х.НАРАНЖАРГАЛ
ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТӨВ ТББ:**

Эрүүгийн хуульд гүтгэх гэмт хэрэг байх нь шударга шүүмжлэлийг боомилох, олон ургальч үзлийг хязгаарлах сөрөг нөлөөтэй...



**ДОКТОР
О.МӨНХСАЙХАН:**

Сэтгүүлчид нийтийн ашиг сонирхлыг хөндөж, эрх мэдлийг урвуулан ашигласан, хууль зөрчсөн, авлига авсан тэр бүх зүйлийг олон нийтэд хүргэх, иргэд тэрийг нь мэдэх үүргийг гүйцэтгэдэг...



**ТОБИ МЕНДЭЛ,
КАНАД УЛСЫН ХУУЛЬЧ:**

Гүтгэлгийг эрүүгийн хуульдаа буцааж оруулах гэж буй улс Монголоос өөр байхгүй...

Ер нь соёлт хүн төрөлхтөн гүтгүүлсэн гэж гомдож байгаа хүний нэр төрийг сэргээхэд анхаарал хандуулж байгаа болохоос хэн нэгнийг шоронд явуулахыг зорьдоггүй. Тархсан арга хэлбэрээр нь, гарсан зардлынх нь хэмжээгээр залруулах нь гол бөгөөд тэр зардлаа шүүхээр албадуулж гаргуулдаг байж хувь хүний нэр төр, эрхэмсэг оршихуй хамгаалагдана. Гэтэл манайд гүтгүүлсэн иргэн хохирлоо барагдуулж чадахгүй байна.

ШИГТГЭЭ

Гаалиас төрсөн тэрбумтан гээд бичтэл, гүтгэсэн гээд 100,000 төгрөгөөр торгосон. Гэтэл нөгөө хүн нь авлига авсан хэрэгт холбогдоод хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болсон тохиолдол байдаг.

Хэлэлцүүлгийн зочин, хуульч Х.Тэмүүжин

Туул гол руу бохироо хаяж байна гэж бичмэгц www.amjilt.com цахим хуудсыг хаасан. Үндэслэл нь зохиогчийн эрхийг зөрчсөн гэж үзсэн. Зөрчлийн хуулиар байгаль орчны хамгаалагч байгаль орчны төлөө үзэл бодлоо илэрхийлсний улмаас гэрээ зарж, 2 сая төгрөг төлөхөд хүрсэн жишээ байна.

Хэлэлцүүлгийн оролцогч Глоб интернэшнл төв ТББ-ын Тэргүүн Х.Наранжаргал

Хоёр сая төгрөгөөр торгуулсан хоёр сэтгүүлчтэй ярилцахад торгуулийг нь гомдол гаргасан улс төрчид нь төлсөн гэж байна.

Хэлэлцүүлгийн зочин, хуульч Б.Энхбаяр

ШИГТГЭЭ

Саяхан Болд, Хурц нарын хэрэг хяналтын шатаар орсон. Нэхэмжлэгч Болд нь хариуцагч Хурцыг “Хойд Солонгосын хоёр иргэн Болдоос болж цаазлагдсан” гэж гүтгэсэн хэмээн нэхэмжлэл гаргасан. Улсын дээд шүүх нэр төрд халдсан гээд тогтоосон. Гэвч энэ тохиолдолд хариуцагчийн зүгээс нотлох боломжгүй. Энэ мэт нэхэмжлэгч, хариуцагчийн зүгээс нотлох боломжгүй олон тохиолдол цахим орчинд гардаг болсон. Үүнийг хэн тогтоох вэ гэхээр гуравдагч этгээд буюу нотлох хууль зүйн процесстой этгээд болох төр тогтооно. Үүний тулд энэ нь эрүүгийн хуульд бичигдэж байж хэрэгжинэ.

Хэлэлцүүлгийн зочин, хуульч Б.Энхбаяр

Тухайлбал, Зөрчлийн хуулиар гүтгэлгийн маргааныг шийдсэнээр хоёр иргэний дундын маргаанаас төр орлого олдог гажуудал бий болоод байна. Хоёр иргэн маргаад эрхээ сэргээлгэж, хохирлоо барагдуулах гэхээс илүүтэй төр хувь хүнээс 2 сая, хуулийн этгээдээс 20 сая төгрөгийн торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлэх болжээ. Тиймээс монголын эрх зүйн орчин хохирогчийн хохирлыг барагдуулах тал дээр анхаарах шаардлагатай.

ГҮТГЭЛГИЙГ ГЭМТ ХЭРЭГТ ТООЦОХ ЗААЛТ НЬ НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ХОРООНЫ ЗӨВЛӨМЖИД НИЙЦЭЖ БУЙ ЭСЭХ

Эрүүгийн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд туссан “гүтгэх” гэмт хэрэгт зөвхөн торгох, зорчих эрхийг хязгаарлах ял ногдуулахаар байгаа. Мөн улс төрд нөлөө бүхий этгээд “гүтгэх” гэмт хэргээр гомдол гаргах эрхийг хаасан заалт оруулсан. Ийнхүү томьёолохдоо

нэгдүгээрт Зөрчлийн хуульд байгаа торгуулийн хэмжээг нэмэгдүүлэхгүй, харин ч бууруулах зарчим барьсан. Тухайлбал, илт худал мэдээлэл тараавал хүнийг 450,000-2,000,000, хуулийн этгээдийг 450,000 – 10,000,000 төгрөгөөр торгохоор болгосон.

ШИГТГЭЭ

Хуулийн тогтолцоонд нэг гажуудал байна. АНУ-д торгууль төлөх боломжгүй, төлөх сонирхолгүй. Тэргэнцэртэй хүний зогсоолд машин тавибал 400 ам.доллар. Тэгэхээр манайд торгууль төлөх боломжтой байх ёстой гэсэн зарчим үйлчлээд байна. Уул нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс торгуулийн хэмжээ өндөр байх ёстой. 5000, 10000 төгрөгөөр торгох биш 500000, 1000000 болговол зөрчихөө болино.

Хэлэлцүүлгийн оролцогч Д.Сүхгэрэл, Оюу толгой хяналт ТББ

ШИГТГЭЭ

“Гүтгэх” нь гэмт хэргийн шинжтэй бол эрүүгийн хуульд тусгах нь олон улсын хэм хэмжээг зөрчихгүй.

Хэлэлцүүлгийн оролцогч Доктор Г.Нарантуяа

Ер нь бусдыг гутаан доромжлох, бусдын эд хөрөнгө, эсхүл компанийг нь тэр чигээр нь дээрэмдэж авах зорилготой, эсхүл энэ хүнийг байхгүй болгоё гэсэн үйлдэл бол гэмт хэрэг мөн. Гүтгэх үйлдэлдээ хэвлэл мэдээллийн хэрэгслийг зэвсэг болгон ашиглаж байгааг хууль сахиулах байгууллага тогтоохдоо алдаа гаргаж, хэвлэл мэдээллийн байгууллагыг л шийтгээд байна. Харин гүтгэсэн этгээдийг орхигдуулаад байна. Энэ үзэгдэл нарийсаж байгаа тул үүнийг гэмт хэрэгт тооцох нь зөв юм. Цаашдаа зохицуулалт сайжрах юм бол иргэний хуулиар зохицуулагдахыг үгүйсгэхгүй.

Хэлэлцүүлгийн оролцогч Доктор Г.Батзориг

Шаардлагатай бол процессын хуульд энэ гэмт хэрэгт гүйцэтгэх ажил хийхгүй, цагдан хорихгүй гэсэн тусгай зохицуулалт оруулах боломжтой.

Хэлэлцүүлгийн зочин, хуульч Б.Энхбаяр

Эрүүгийн хууль руу оруулаад дотор нь байгаа үзэгдлүүдийг ялгаж салгалгүй биччихээр төрийн байгууллагын нууц далд аргаар шалгадаг механизм ороод л ирнэ. Оргон зайлж болзошгүй, дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй гээд цагдан хорьж, нухчин дарах боломж гараад л ирнэ. Тэгэхээр гэмт хэрэгтэй тэмцдэг төрийн арга барил юу билээ гэж бодож байж гэмт хэрэг болгож бичихгүй бол өмнө нь эрүүгийн хуульд байхад сэтгүүлчдийн холбогдсон хэрэг бага байсан гээд биччих юм бол одоо улс төрийн өнгө өөр байгаа гэдгийг бодолцох хэрэгтэй.

Хэлэлцүүлгийн зочин, хуульч Х.Тэмүүжин

Хүнийг хүнд гэмт хэрэгт буруутгаж байгаа бол эрүүгийн хуулиар зохицуулагдах ёстой. Харин одоо яригдаж байгаа нэмэлт өөрчлөлт нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд зүй бус хязгаарлалт болох гээд байгааг анхаарч үзэх хэрэгтэй. Тиймээс өнөөдрийн байдалд тохируулж хууль бичих биш, Үндсэн хуульдаа тохируулах шаардлагатай. Бидэнд мэдэхгүй зүйл олон байна. Тухайлбал, гүүгл (google) үндэсний шүүх дээр ялсан бол хайлтын системээс “гүтгэсэн” мэдээллийг устгах зохицуулалттай. Гэтэл манайд үүнийг мэдэхгүйгээс хайлтын системд тэр мэдээлэл нь байж л байдаг. Бусад цахим системд ч мөн адил өөрийн зохицуулалт байгаа. Тиймээс иргэдийн мэдээллийн боловсрол (media literacy)-ыг нэмэгдүүлэх шаардлагатай. Өнөөдөр яригдаж байгаа асуудлын тухайд хэрэв эрүүгийн гэмт хэрэгт тооцох бол одоогийн бичсэн хоёр зүйлээс татгалзаад илүү хүнд ноцтой шинж бүхий гэмт хэргийг тусгах шаардлагатай.

Хэлэлцүүлгийн оролцогч Глоб интернэшнл төв ТББ-ын Тэргүүн Х.Наранжаргал

Эрүүгийн хуульд гэмт хэрэг бүр харилцан адилгүй, санаа зорилго, цар хүрээ, агуулга, түгээх хэлбэр өөр тул оногдуулах шийтгэл харилцан адилгүй байдаг. Зөрчлийн хуульд бол үүнийг харгалзаж үзэлгүй, тогтоосон хэмжээгээр л торгууль оногдуулдаг. Тиймээс ч тус хуулиар 20 сая төгрөгөөр торгуулсан хэвлэл мэдээллийн хэрэгсэл (ХМХ) байхгүй, бүх бурууг сэтгүүлчид тохоод редакц хариуцлагаас

мултардаг практик тогтоод байна. Нөгөө талаас улс төрчид, эрх мэдэлтэй хүмүүсийн хувьд нэр төр маш чухал тул тэд Зөрчлийн хуулийн заалтыг сэтгүүлчдийг өөрийнх нь эсрэг мэдээлэл гаргуулахгүй байх зэвсэг болгон ашиглаж байна. Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд бичигдсэн “гүтгэх” гэмт хэргийн ялын хэмжээг аваад үзвэл энэ нь хөнгөн гэмт хэрэг юм.

ГҮТГЭЛГИЙГ НЭГ ХУУЛИАР ШИЙДЭХ БОЛОМЖГҮЙ

Гүтгэлгийн холбогдолтой асуудлыг нэг хуулиар, нэг арга замаар шийдэх боломжгүй. Тухайлбал, хэвлэлийн эрх чөлөөнд хамаарах иргэдийн төрийг хянах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй холбоотойгоор учир дутагдалтай зохицуулалтууд олон байна. Бусад улс оронд төрийн албан хаагч болон олон нийтийн зүтгэлтэн (public figure) ямар нэг асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэгт өртвөл, эхлээд аль нэг шүүхэд хандах гэхээс өмнө тэр хэлэлцэгдэж байгаа асуудалтай холбогдуулан тайлбар хийх үүрэгтэй байдаг.

Ганц иргэний хуулиар хамгаалагдах нь харин ч эрсдэлтэй. Тухайлбал, нэр төрөө тэрбумаар үнэлж нэхэмжлэл гаргаж байна, энэ бол маш их мөнгө. - Б.Энхбаяр

V.

Иргэний хуулийн 1 тэрбумын асуудал бол соёлын асуудал. Энэ бол эдийн засгийн цензур. - Х.Наранжаргал

Монголд энэ төрлийн зохицуулалт байхгүй тул өөрийг нь шүүмжилсэн, эсхүл төрийн албыг ил тод болгох гэсэн үйлдлийг шууд хуулийн байгууллагаар таслан зогсоолгох гэж оролдож байна. Үүний зэрэгцээ мэдээллийнх сурвалжаа хамгаалах асуудлыг хуульчлаагүй. Тиймээс зөвхөн эрүү, иргэний хуулиар зохицуулах гэх биш хэвлэлийн эрх чөлөөний тухай хуульд нь шаардлагатай зохицуулалтуудыг тусгаж өгөх нь зүйтэй. Ийнхүү цогцоор шийдэхгүй бол иргэд төрийн албыг хянах, шүүмжлэх боломжгүй болно. Нөгөө талаас, эрүүгийн хуульд “гүтгэх” гэмт хэрэг бичсэн ч тэр гэмт хэргийн ойлголт бүдэг бадаг байх юм бол ямар эрсдэл учрахыг тооцох ёстой. Учир нь, хуулиар төрийн байгууллагад хэдий чинээ эрх хэмжээ олгоно, нөгөө талдаа энэ нь зүй бусаар ашиглагдах эрсдэл байнга байх болно гэдгийг мартаж болохгүй.

ШИГТГЭЭ

Цагдаагийн байгууллагын дэд даргын гомдлоор цагдаагийн байгууллагыг гүтгэсэн гэсэн үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэх гэж оролдож байсан. Тиймээс бид сайн санааны үүднээс гэмт хэрэг гэж бичихдээ энэ нь хэн нэгний зэвсэг болж, хүний эрх, эрх чөлөөнд халдах үүд хаалгыг нээхгүй байх ёстой. Үгүй бол манайх шиг дөнгөж бойжиж байгаа ардчилал, хуулийн засаглалд хүний эрхийг юман чинээ тоохгүй дайраад гарах улс төрийн соёл амь бөхтэй байна. Энэ бүхнээс үүдээд гүтгэх нь төрийн тусгай хэрэгсэл, хүч, тэр эрх мэдлийн үзүүрт байхаас илүүтэй иргэд хоорондын маргааны талбарт байх нь зохимжтой.

Хэлэлцүүлгийн зочин, хуульч Х.Тэмүүжин

“ГҮТГЭХ ГЭМТ ХЭРЭГ”-Т ЯМАР ҮЙЛДЛҮҮД ХАМААРДАГ БОЛОХ, ЗОХИЦУУЛАЛТ ОНОВЧТОЙ ЭСЭХ, ЦАХИМ ОРЧИНД ҮЙЛДЭГДЭЖ БАЙГАА “ГҮТГЭХ” ҮЙЛДЛИЙГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖТОЙ ВЭ?

Социалист нийгмийн үед томьёолсон “гүтгэх” гэмт хэргийг задалж үзэх шаардлага тулгарч байна. Хэт олон асуудлыг энэ үйлдэлд хамааруулж ойлгоод, дүнд нь эрүүгийн гэмт хэрэгт тооцох ёстой гэсэн шийдэлд хүрээд байна. Тиймээс “гүтгэлэг” гэдэг гэмт хэрэгт өөр төрлийн

гэмт хэргийн шинжийг нэмж байгаад “ийм аюултай” гээд эрүүгийн хуульд бичих нь буруу. Харин тэр аюултай шинжтэй гэмт хэргээ нарийвчлан тодорхойлоод эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой. Тухайлбал, тодорхой санхүүжилт гаргаад, төрөөс юм уу албан тушаалтнуудаас хүсэж байгаа шийдвэрээ гаргуулах зорилготой “гүтгэх” үйл ажиллагааг зохион байгуулалттай явуулж байгаа бол энэ нь гүтгэх гэмт хэрэгт хамаарах биш харин үүнийг шинээр гэмт хэрэг болгон томьёолох шаардлагатай.

Цахим орчинд зохион байгуулалттай үйлдэгдэж байгаа гэмт хэргийг “гүтгэх” гэмт хэрэгт холбогдуулахаас өөрөөр авч үзэх шаардлагатай. Монголын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд “гүтгэх” гэдэг гэмт хэрэгт маш олон зүйлийг нэгтгэж ойлгоод байдаг. 2015 оны Эрүүгийн хуульд “түрэмгий дайн өдөөхийг нийтэд уриалах” гээд шинэ гэмт хэрэг бичсэн. Үүнтэй адил төстэй шинэ төрлийн гэмт хэрэг бичих үү, үгүй юу гэдэг дээр улс орнууд санал зөрөлдөөнтэй байна. Хүний эрхээс харьцангуй хол, улс төрийн зохион байгуулалт нь хагас диктатур маягийн улс орнууд энэ төрлийн гэмт хэргийг “олон нийтэд худал мэдээлэл

ШИГТГЭЭ

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, халдашгүй байх эрхийн зөрчилдөөнийг зохицуулах ухаалаг шийдэл эрэлхийлэхийн оронд төр илүү эрх мэдэлтэй болох арга замыг сонгох нь зөв биш ээ. Жишээ хэлэхэд, саяхан болж өрнөсөн үйл явдал бол шүүх болохгүй байна, хуулийн байгууллагууд ялзарч байна гэсэн нэрийн доор өөр хүмүүс эрх мэдлээ нэмэгдүүлэх замаар асуудлаа шийдэхгүй орхиж байна. Тэгэхээр нэг талдаа гүтгэх, нөгөө талдаа нэр төрөө сэргээлгэх гэсэн хоёр иргэний орон зайд төр өөрийн эрх мэдэл, хүч хэрэгслээр орж, хувь хүний орон зайд төрийн оролцоог нэмэгдүүлнэ гээд явах юм бол энэ мэт байдлаар их олон гэмт хэрэг нэмэгдэх болно.

Хэлэлцүүлгийн зочин, хуульч Х.Тэмүүжин

түгээсэн бол ийм гэмт хэрэг” гээд маш хялбар хуульчилдаг бол хүний эрхийг дээдэлдэг улс орнууд шууд гэмт хэрэг болгон томьёолохоос болгоомжилж байна.

Энэ хүрээнд өөр нэг яригдах асуудал бол хувь хүмүүсийн мэдээлэл цуглуулах замаар хүмүүсийг дарамтлах үйлдэл юм. Тэгэхээр энэ төрлийн гэмт үйлдэл “гүтгэх” гэмт хэрэг бий болсноор шийдэгдэж чадах уу гэдгийг бодолцож үзэх шаардлагатай. Өөр нэг гэмт үйлдэл бол “экстрим үйл ажиллагаанд уриалах” биш ч тодорхой мэдээллийг илт гуйвуулах замаар түгээж, нийгмийг айдас түгшүүрт автуулах аргаар тодорхой зорилгоо биелүүлэх алхмууд юм. Тиймээс эдгээр шинэ үзэгдлийг ямар арга замаар шийдэхээ задалж харахгүй нэг гэмт хэрэгт хамааруулах нь эрсдэлтэй.

Гэтэл монголд “гүтгэх” гэдэг үйлдлийг эрүү, зөрчилд бичсэнээр энэ бүх асуудал шийдэгдэнэ гэж үзээд байгаа нь учир дутагдалтай. Нөгөө талаас, иргэн хоорондын маргаан дээр дөрөөлж төр орлого олж, эрх мэдэл олоод байна. Тиймээс хуулийн ямар зохицуулалт байх нь ухаалаг, илүү үр дүнтэй вэ гэдгээ анхаарах ёстой. Үүнийг криминологичид нарийвчлан судлах шаардлагатай байна.

“ҮЗЭЛ БОДОЛ”, “ШИЙДЭЛ СОНГОЛТ” ЦУВРАЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Нээлттэй Нийгэм Форум нь маргаан бүхий асуудлаар эсрэг тэсрэг үзэл бодлыг уралдуулах, зарчмын зөрүүтэй байр суурийг сонсох, талуудыг мэтгэлцүүлэх замаар иргэдэд тухайн асуудалтай гүнзгий танилцах, улмаар бодлогын шийдэлд мэдлэгтэй, мэдээлэлтэй оролцох боломжийг олгох зорилгоор “Үзэл бодол”, “Шийдэл сонголт” цуврал мэтгэлцээн, хэлэлцүүлгийг зохион байгуулж байна.

Одоогийн байдлаар хэлэлцүүлэг дараах сэдвээр зохион байгуулагдаад байна. Үүнд:

- Гүтгэлэг гэмт хэрэг мөн үү?
- Хуулийн этгээдээс улс төрийн нам, нэр дэвшигчид хандив өгөх нь зөв үү?
- Сонгуулийн төлбөртэй сурталчилгааг хориглох нь зөв үү?
- Эрүүгийн хэргийг шүүхээс буцаах нь буруу?

Дээрх сэдвүүдээр явагдсан мэтгэлцээн, хэлэлцүүлгийг Та www.forum.mn вэбсайтын видео цэс, мөн www.youtube.com дэх сувгаас бүрэн эхээр нь үзэх боломжтой.

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРМ

ННФ-ын үйл ажиллагааны гол зорилго нь чанартай мэдээлэл, судалгаанд үндэслэсэн бодлогын үр нөлөөтэй, олон талын оролцоог хангасан өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнүүлэх, төрийн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд иргэд, иргэний нийгмийн идэвхтэй оролцоог дэмжих явдал юм.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОГЧИД

1. Б.Алтантуяа, Монголын Эмнести Интернэшнл
2. Б.Амгалан, Нээлттэй Нийгэм Форум
3. Ш.Ариунаа, Монголын Эмэгтэйчүүдийн Хөдөлмөрийг Дэмжих Холбоо
4. О.Ариунбилэг, www.gogo.mn
5. П.Бадамрагчаа, Нээлттэй Нийгэм Форум
6. З.Бадмаараг, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс
7. Д.Балжид, Нээлттэй Нийгэм Форум
8. Б.Батзориг, Санхүүгийн Зохицуулах Хороо
9. Б.Батзаяа, Нээлттэй Нийгэм Форум
10. Б.Баттуул, Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх Олон улсын хүрээлэнгийн Монгол дахь төслийн зохицуулагч
11. И.Батцэцэг, Усны академи
12. Б.Болорсайхан, Монголын Эмнести Интернэшнл
13. Ц.Ганболд, Монголын Хуульчдын Холбоо
14. Л.Данзанноров, Хуульч
15. О.Дүүрэнжаргал, Хэвлэл мэдээллийн зөвлөл
16. Ц.Жаргалан, Монголын Хуульчдын Холбоо
17. Г.Золжаргал, НҮБХХ-ийн төсөл
18. Б.Мөнхбат, Хуульч
19. Б.Мөнхдорж, Хууль Сахиулахын Их Сургууль
20. С.Мөнхцэцэг, Хуульч
21. Г.Наранбаатар, Өмгөөлөгч
22. Х.Наранжаргал, Глоб Интернэшнл Төв
23. Г.Нарантуяа, Хүний эрхийн эксперт, Доктор
24. Л.Ононбаяр, Өмгөөлөгч
25. Д.Сүхгэрэл, Оюу Толгойн Хяналт ТББ
26. Д.Түвшинтамир, Өмгөөлөгч
27. Д.Энхцэцэг, Нээлттэй Нийгэм Форум
28. П.Эрдэнэжаргал, Нээлттэй Нийгэм Форум
29. Д.Эрдэнэчимэг, Нээлттэй Нийгэм Форум